

**ОРЧИН ҮЕИЙН СОЛОНГОСЫН ПАРЛАМЕНТЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ<sup>70</sup>****Ж.Төртогтох** доктор, дэд профессорМУИС, НШУС, Улс төр судлалын тэнхим  
Орчин үеийн улс төрийн судалгааны төвийн эрхлэгч

Энэхүү өгүүлэлд Солонгосын хууль тогтоох институтын түүхэн ба үндсэн хуулийн үндэс суурийн талаар авч үзнэ. Солонгосын парламентын түүх нь хөгжил, өөрчлөлт, даваа бэрхшээлийн олон үе шатыг даван туулж ирсэн баялаг уламжлалтай билээ. Хууль тогтоох институтын ач холбогдол ба түүхэн хөгжлийн асуудлыг парламентын эрдэмтэд (Kim ба Pai, 1981; Yoon, 1991; Park, 1998: 66-68, 2002a: 330-32) төдийгүй Үндэсний Ассамблейн гишүүн асан зэрэг улс төрчид, улс төрийн зүтгэлтнүүд ч (Kil, 1964: 1-12; Pak, 1976: 115-34) олон талаас нь авч үзэж судалсан байдаг. Тухайлбал, Пак (1998) Солонгосын хууль тогтоох институтын бодлого, үйл ажиллагааг тухай тухайн үеийн түүхэн нөхцөл байдалд хэрхэн уялдаж өөрчлөгдөж ирсэн талаас нь нарийвчлан авч үзсэн нь бий. Пакын хураангуйлан дүгнэснээр, Солонгосын Үндэсний Ассамблей нь харьцангуй богино боловч ээдрээт, зөрчилдөөнт түүхтэй билээ (Pak, 1976: 115).

**Түлхүүр үгс:** Солонгосын Үндэсний Ассамблей, хууль тогтоох институт, үндсэн хууль, Солонгосын улс төр

**Бүгд найрамдах улсын үүсэл**

Солонгосын хууль тогтоох байгууллагын талаар үндсэн хуулийн системд тулгуурлан авч үзэхийн өмнө орчин үеийн Солонгосын улс төр ба парламентын институтын түүхэн үүсэл хөгжлийг товч авч үзье.

Потсдамын тунхаглалын<sup>71</sup> дагуу 1945 оны 8 дугаар сарын 15-нд Солонгос нь 36 жил үргэлжилсэн колоничлолоос ангижирч тус үндэстэн эрх чөлөөгөө эргүүлэн олж авсан билээ. Тухайн үедээ үндэсний энэхүү чөлөөлөлт ба улс төрийн итгэл найдвар Солонгосын ард иргэдийн хувьд тийм ч амар байгаагүй юм. АНУ, Британи, Хятад зэрэг улс гүрнүүдийн Рузьвелт, Черчилл, Чан Кайши нараар дамжсан харилцан тохиролцоо, гэрээнд зааснаар "Японы бүрэн эрхт байдал нь энд бидний"<sup>72</sup>

<sup>70</sup> This paper was made possible through a field research grant from the Korea Foundation. The author is grateful to the Korea Foundation for its support for this ongoing effort.

<sup>71</sup> The Potsdam Declaration or the Proclamation Defining Terms for Japanese Surrender нь 1945 оны 7 дугаар сарын 26-нд тунхаглагдсан.

<sup>72</sup> Потсдамын Тунхаглалыг Harry S. Truman, Winston Churchill, Chiang Kai-shek нар харилцан тхирч баталсан болно.

тогтоосон арлуудаар хязгаарлагдах”<sup>73</sup> болж, хэрэв Япон дайны байдлыг зогсоохоос татгалзвал, “хэрэгцээтэй цагт нь шаардлагатай эрс арга хэмжээ”<sup>74</sup> авахаар болжээ. Эвслийн эдгээр гүрнүүд яг энэ үед Солонгосыг чөлөөт ба тусгаар тогтносон байхыг заасан. Гэвч бодит байдал дээр Зөвлөлтийн болон АНУ-ын цэргийн удирдлага Солонгосын хойгт энэ үеэс эхлэн тогтсон байна. Солонгосын анхдугаар Ассамблейн гишүүн асан Пак Чан Хёны тэмдэглэснээр:

... манай үндэстэн өмнөддөө АНУ-ын, умарддаа Зөвлөлтийн цэргийнхэнд Солонгос дахь Японы цэргийн хүчний зэвсгийг хураах “цорын ганц зорилгын” үүднээс 38 дугаар өргөргийн дагуу тус тус эзлэгдсэн юм. Гэвч, хоёр хүчирхэг гүрний энэхүү эзлэлт нь тус улсыг хоёр хэсэг болгон хуваасан үр дүнг л авчирсан (Пак, 1976: 115)

Тэдгээр гүрнүүдийн цэргийн удирдлага тогтсон гурван жилийн дараа хойгийн өмнөд хэсэгт Бүгд Найрамдах Солонгос Улс байгуулагдсан юм. 1948 оны 5 дугаар сарын 10-нд НҮБ болон Солонгосын түр комиссын хяналтан дор 38 дугаар өргөргийн өмнөд хэсэгт анхдугаар Үндэсний Ассамблейг сонгох бүх нийтийн, ардчилсан сонгууль болжээ (Зураг 1.-ийг үзнэ үү).

**Зураг 1. 1948 оны 5 дугаар сарын 10-нд болсон бүх нийтийн анхны сонгуулиар сонгогчид саналаа өгч буй байдал**<sup>75</sup>



<sup>73</sup> Potsdam Declaration: Proclamation Defining Terms for Japanese Surrender, 1945: Article 8.

<sup>74</sup> Мөн тэнд, Article 13.

<sup>75</sup> Зургийг зохиогчийн 2008-2009 онд хийсэн судалгааны бүтээлд ашиглаж байсан зургаас хуулбарлан оруулав.

Дараахан нь 5 дугаар сарын 31-нд Ассамблейг зохион байгуулжээ. Анхдугаар Ассамблей нь бүх нийтийн, тэгш, шууд, нууц сонгуулиар сонгогдсон 198 гишүүнээс бүрдсэн. Гэвч Солонгосын ард иргэдийн хувьд шинэ үндэстнийг байгуулах ардчилсан арга замд тулгуурласан үндэсний зөвшилцөл бүхий бүх нийтийн энэхүү сонгуулийг явуулах нь амар хялбар байсангүй. Пакийн цохон дурьдсанаар Солонгосчууд нь:

улс орон хоёр хэсэг хуваагдаж эхэлж байсантай холбоотойгоор коммунистуудтай сөрөн тэмцэж байсан юм. Бид АНУ-ын цэргийн удирдлагаас шилжилтийн түр засгийн эрхийг шилжүүлэн авч үндэсний тусгаар тогтнолыг зарлан тунхаглахын тулд өөрийн засаг төрөө эмхлэн байгуулах нь маш хүнд хэцүү зорилт байсан. Саад бэрхшээл, аллага хядлага зэргийг даван туулангаа Солонгосын ард түмэн бүх нийтийн сонгуулиа амжилттай явуулж, анхдугаар ассамблейгаа зохион байгуулж чадсан юм (Pak, 1976: 116-117).

## Зураг 2. Анхдугаар Үндэсний Ассамблейн чуулганы нээлт<sup>76</sup>



<sup>76</sup> Зургийг зохиогчийн 2008-2009 онд хийсэн судалгааны бүтээлд ашиглаж байсан зургаас хуулбарлан оруулав.

Анхдугаар Ассамблейд сонгогдсон дотор Японы колоничлолын эсрэг эрх чөлөөний төлөө тэмцэл, тусгаар тогтнолын төлөөх хөдөлгөөнүүдэд шууд ба шууд бусаар нэгдэн оролцож байсан маш олон эх орончид байсан юм (Зураг 2-ийг үзнэ үү). Анхдугаар Үндэсний Ассамблей нь хоёр жилийн турш ажиллахдаа хоёр удаа ээлжит, дөрвөн удаа тусгай чуулганы хэлбэрээр нийт зургаан удаа чуулсан байна (Kil, 1964: 4). Энэхүү анхдугаар Үндэсний Ассамблейгаар 1948 оны 7 дугаар сарын 12-нд анх удаагаа ардчилсан Үндсэн хуулийг тогтоосон билээ. Улмаар Ассамблей 1948 оны 7 дугаар сарын 17-нд Үндсэн хуулийг батламжилсан юм. Түүнээс инагш, үндсэн хууль нь засаглахуйн гол цөм нь болж, бахархалтай нь үндсэн хуульт ёс хэмээх нэр томъёо нь үндсэн хуульт засаг төрийн тулгуур зарчимд итгэх итгэлийнхээ хувьд Солонгосын улс төрийн амьдрал, харилцааны уулзвар, холбогч нь болсоор иржээ. Үндсэн хуулийн текстийг үг үгээр нь уран бичлэгийн бийрээр нямбайлан бичсэн (Pak, 1976: 120) хэдий ч харамсалтай нь Солонгосын дайны үеэр уг эх бичлэг нь устан алга болсон юм.

Үндсэн хуулийн анхны агуулга нь ерөнхийлөгчийн системийг тогтоосон. Гэвч үндсэн хуулийн төслийн хувилбарыг бэлтгэж байх үед парламентын кабинетын систем ба ерөнхийлөгчийн засаглалын систем хоорондоо өрсөлдөж байжээ. Анхдугаар Ассамблейгаас томилон ажиллуулсан Үндсэн хуулийн Төслийн Хороо<sup>77</sup> үндсэн хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлсэн. Ингэхэд Хорооны ихэнх гишүүд засаглалын дарламентын системийг дэмжиж байсан бол хожим нь Анхдугаар Ассамблейн спикер болсон доктор И Синман засаглалын хүчтэй ерөнхийлөгчийн системийг сонгосон юм (Park, 1962: 23-34). Харин Солонгосын ард иргэдийн санаа бодол тухайн үедээ парламентын кабинетийн системийг дэмжиж байсан ажээ (Pak, 1976: 123). Үр дүнд нь, И Синман АНУ-ын ерөнхийлөгчийн системтэй маш төстэй системийг гаргаж ирсэн. Засаглалын системийн хэв маягийг сонгох тал дээрх И Синманы байр суурьд Пак Чи Ён анализ хийхдээ:

Тэрээр ерөнхийлөгчийн системийг илүү дээрд үзэх өөрийн үндэслэгээгээ дараах байдлаар гаргасан юм. Нэгд, БНСУ-д төр улсыг байгуулан тогтоох зорилгыг биелүүлж чадах, амжилт гаргахуйц улс төрийн удирдлага бүхий тогтвортой засаг төр шаардлагатай байсан, хоёрт, Солонгост коммунизмын эсрэг амжилттай сөрөн зогсохын тулд хүчирхэг засаг төр туйлын чухал шаардлагатай байсан бөгөөд хуваагдсан Солонгосын хувьд тогтвортой бус байдал, улс төрийн хурц сөргөлдөөн, хямралыг

<sup>77</sup> Тухайн үедээ, Үндсэн хуулийн Төслийн Тусгай Хороо нь ассамблейн 30 гишүүн, түүнчлэн бусад 10 эксперт, мэргэшсэн зөвлөхүүдээс бүрдэж байсныг Пак номондоо тэмдэглэсэн байна (Pak, 1976: 123).


урин дуудаж болзошгүй парламентын системийг тогтоох талаар бодох ч хэрэггүй, гуравт, улс төрийн эсрэг тэсрэг бүлэг, талуудын хоорондын сөргөлдөөнд хүргэж болзошгүй парламентын систем байх нь тохиромжгүй, учир нь Солонгосын түүх нь эцэстээ 1910 онд Японы колони болоход хүргэж байсан тийм бүлэг, талуудын тэмцэл, мөргөлдөөний жишээгээр дүүрэн гашуун туршлага байсан юм (Pak, 1968: 111).

Анхны Ерөнхийлөгчийг 1948 оны 7 дугаар сарын 20-нд Үндсэн хуулийг батламжилснаас ердөө гурав хоногийн дараа анхны хууль тогтоох институтээс сонгосон юм. Анхдугаар Ассамблейн спикер И Синманыг тийнхүү анхны ерөнхийлөгчөөр сонгосон байна. Ийнхүү хэдийгээр Үндсэн хууль нь ерөнхийлөгчийн системд үндэслэсэн боловч энэ нь яг АНУ-ын ерөнхийлөгч шиг хүчтэй засаглал биш байсан юм. Шинэ Үндсэн хуулийн дагуу Америкийн ерөнхийлөгчийн систем болон Британийн парламентын систем хосолсон бүгд найрамдах засаг тогтсон. Үүний зэрэгцээ, Үндсэн хуулиар либерал ардчиллыг тогтооход улс төрийн лидерүүдэд суурь үнэт зүйл болсон хувь хүний үндсэн эрх, эрх чөлөөг бүрэн баталгаажуулсан ажээ (Kim ба Pai, 1981: 23).

#### ***Солонгосын хууль тогтоох институтын бойжилт***

Солонгосын парламентын институт нь хөгжилд тэмүүлсэн өөрчлөлт, сорилт бэрхшээлээр баялаг түүхтэй билээ. Хууль тогтоох институтын түүхэн хөгжил, ач холбогдлын талаар парламентын эрдэмтэд (Kim ба Pai, 1981; Yoon, 1991; Park, 1998: 66-68, 2002a: 330-32), түүнчлэн Үндэсний Ассамблейн гишүүн асан улс төрчид (Kil, 1964: 1-12; Pak, 1976: 115-34) тал бүрээс нь судалж үзсэн байдаг ажээ. Тухайлбал, Пак (1998) Солонгосын хууль тогтоох институтын бодлогын үйл ажиллагааны өөрчлөлтийг түүхэн нөхцөлд нь холбон судалсан байдаг. Пакын ач холбогдол өгсөнчлөн, Солонгосын Үндэсний Ассамблей нь харьцангуй богино боловч зөрчил тэмцэл, өрнөл хөгжлөөр дүүрэн түүхтэй юм (Park, 1998: 68). Зохиогч үүнтэй санал нэг байгаа хэдий ч зөвхөн парламентын институциональ өөрчлөлттэй холбон үзээд зогсолгүй басхүү орчин үеийн Солонгосын улс төрийн хөгжилд ч хамаарах дүгнэлт гэж үзэж байна.

## Зураг 3. Солонгосын Үндэсний Ассамблейн барилга (БНУ-ын эхэн үед)



Анхдугаар Бүгд найрамдах улсын эхэн үеэс өнөөгийн ҮИ БНУ-ыг хүртэл Солонгос нь улс төрийн дараалсан олон өөрчлөлтүүдийг туулсан байдаг. Үүнтэй холбогдуулан, Солонгосын улс төрийн систем дэх хууль тогтоох институтын байр суурь ихээхэн өөрчлөгдөж ирсэн (Хүснэгт 1-ийг үзнэ үү). Үндсэн хуулийн нөлөөгөөр хууль тогтоох институт нь улс төр, засаглалын гол цөм болсон байна (Kim ба Pai, 1981: 23). Тухайлбал, IY БНУ-ын үеийн Үндэсний Ассамблейн хувьд, Мези бодлого боловсруулах эрх мэдлээр бага бөгөөд харьцангуй бага дэмжлэг хүлээж байсан хэмээх ангилалд хамааруулж үзсэн байх жишээтэй (Mezey, 1979: 21-44).

Хүснэгт 1. Солонгосын Үндэсний Ассамблейн түүхэн хронологи

Бүгд найрамдах Улс	Дэглэмийн хэв маяг	Засаглалын систем	Ассамблей	Бүрэн эрхийн хугацаа
Анхдугаар	Авторитар	Ерөнхийлөгчийн	Анхдугаар	1948.05 – 1950.05
			Хоёрдугаар	1950.05 – 1954.05
			Гуравдугаар	1954.05 – 1958.05
			Дөрөвдүгээр	1958.05 – 1960.05 (оюутны бослогын улмаас бүрэн эрхийн хугацаагаа дуусгасан)
Хоёрдугаар	Ардчилсан	Парламентын	Тавдугаар	1960.07 – 1961.05 (цэргийн дэглэм тогтсоноор тарсан)
Гуравдугаар	Авторитар	Ерөнхийлөгчийн	Зургадугаар	1963.12 – 1967.06
			Долдугаар	1967.07 – 1971.06
			Наймдугаар	1971.07 – 1972.10 (дайны байдлын хууль гарснаар тарсан)
Дөрөвдүгээр	Авторитар	Ерөнхийлөгчийн	Есдүгээр	1973.03 – 1979.03
			Аравдугаар	1979.03 – 1980.10 (цэргийн дэглэм)

				тогтсоноор тарсан)
Тавдугаар	Авторитар	Ерөнхийлөгчийн	Арваннэгдүгээр	1981.04 – 1985.04
			Арванхоёрдугаар	1985.04 – 1988.05 (ардчиллын төлөөх бослого тэмцлийн улмаас бүрэн эрхийн хугацаагаа дуусгасан)
Зургадугаар	Ардчилсан	Ерөнхийлөгчийн	Арвангуравдугаар	1988.05 – 1992.05
			Арвандөрөвдүгээр	1992.06 – 1996.05
			Арвантавдугаар	1996.05 – 2000.05
			Арванзургадугаар	2000.05 – 2004.05
			Арвандолдугаар	2004.05 – 2008.05
			Арваннаймдугаар	2008.05 – одоог хүртэл (2008 оны 4 дүгээр сарын 9-нд сонгогдсон)

Эх сурвалж: Park: 2002<sup>78</sup>

Үүний адилаар Пак (1998: 68-71) Солонгосын улс төр дэх Үндэсний Ассамблейн байр суурийн талаарх судалгаандаа өнөөгийн ҮИ БНУ-ын жишээн дээр тодорхой авч үзсэн байдаг. Хүснэгт 1.-д үзүүлснээр ҮИ БНУ нь 1988 оны 5 дугаар сараас эхэлсэн бөгөөд өнөөгийн тус БНУ-ын Үндэсний Ассамблей нь үйл

<sup>78</sup> Энэ хүснэгтийн анхны хэлбэр нь Пакийн өгүүлэлд байдаг (Park, 2002: 331). Гэхдээ сүүлийн хоёр мөрийг зохиогч 2005, 2008 онуудад тус тус нэмж оруулсан болно.



ажиллагаагаа явуулсаар байна. Падын илүү нарийн ажигласнаар тухайлбал өнөөгийн ҮИ БНУ-ын эхний хоёр жилийн хугацаанд Үндэсний Ассамблей нь маш хэврэг гэж болохоор хууль тогтоох институт байсан байна. Бодлого боловсруулах эрх мэдлийн хувьд хүчтэй байсан ч тийм ч их дэмжлэг хүлээж байгаагүй. Үүнийг хэврэг хэв маягийн парламентын нэлээн сул дорой хэлбэр гэж болох юм. Улмаар парламентын бодлого боловсруулах эрх мэдлийн цар хүрээ суларсан байдаг. Саяхнаас л парламент нь энэхүү бодлого боловсруулах эрх мэдлийн хувьд авторитар дэглэмийн оргил үетэй харьцуулахад эрч хүчтэй, идэвхтэй байдалтай харагдаж эхэлсэн авч уг эрх мэдэл нь харьцангуй сул байсаар л байна. Парламентыг дэмжих дэмжлэг ҮИ БНУ-ын эхний жилүүдээс инагш суларсаар байгаа юм. Одоогоор<sup>79</sup>, тус хууль тогтоох институт нь завсрын хэв маягийн парламентын харьцангуй хүчтэй хэлбэрээр тодорхойлогдож байна (Park, 1998: 69).

Хэдийгээр БНСУ нь засаглалын ерөнхийлөгчийн систем<sup>80</sup> бүхий улс боловч, тус улсын Үндэсний Ассамблей нь улс төрийн амьдралын хамгийн өрсөлдөөнт<sup>81</sup>, нээлттэй бас ардчилсан биелэл бөгөөд Солонгосын улс төрийн систем дэх үүрэг роль нь маш их юм. Товчдоо, тус улсын парламентын институт нь улс төрийн авторитар болон ардчилсан дэглэмийн үед ч, ерөнхийлөгчийн засаглалын болон парламентын системийн үед ч маш их саад бэрхшээл, улс төрийн хөгжил, төлөвшлийн олон саад бэрхшээл, шатыг даван туулж ирсэн байна.

#### **Орчин үеийн Солонгосын улс төрийн Үндсэн хуульт загвар**

БНСУ-ын Үндсэн хууль нь Солонгосын засаг төрийн гол үндэс нь бөгөөд улс орны дээд хууль нь билээ. 60 гаруй жилийн туршид Үндсэн хууль нь тус улсын засаглалын институтуудын хувьслыг заан чиглүүлж ирсний зэрэгцээ улс төрийн тогтвортой байдал, хувь хүний эрх чөлөө, эдийн засгийн хөгжил, нийгмийн дэвшлийг үндэс суурь болж ирсэн юм. Өнөөгийн үндсэн хуулийн систем нь Үндэсний Ассамблей үндсэн хуулийн төслийг 1987 оны 10 дугаар сарын 12-нд баталж, улмаар 10 дугаар сарын 28-нд зохион байгуулсан ард нийтийн санал асуулгаар сонгогчдын 93 хувийн дэмжлэг авсан үеэс эхтэй юм. Үндсэн хуульт ёсны уг өөрчлөлтөөр засаглалыг авторитар Ү БНУ-аас өнөөгийн засаглалын систем бүхий ҮИ БНУ-д шилжүүлсэн байна. Одоогийн ҮИ БНУ-ын Үндсэн хууль нь 1988 оны 2 дугаар сард Ро Дэ У тус улсын Ерөнхийлөгчийн хувьд батламжилснаар хүчин төгөлдөр болон үйлчилж эхэлжээ.

Үндсэн хуульд БНСУ-ыг засаглан удирдах системийг засаглал хуваарилалт ба харилцан тэнцвэржилтийн зарчимд тулгуурласан ерөнхийлөгчийн систем хэмээн

<sup>79</sup> Энэ өгүүлэл 1998 онд хэвлэгдсэн.

<sup>80</sup> БНСУ-ын Анхдугаар Ассамблейн 1948 онд тунхагласан Үндсэн хуульд энэхүү хэлбэр бүхий засаг төрийг илэрхийлсэн байдаг (Park, 1998: 65).

<sup>81</sup> Kim ба Pai (1981: 37) нарын тэмдэглэснээр энэхүү хууль тогтоох институт төр, иргэнийг холбосон хамгийн чухал институт юм. Энэ утгаар нь уг судалгааны санаа гарч ирсэн болно.

тунхагласан. Үндсэн хуульд зааснаар Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн (*The Constitution of Korea, Article 66:1*) бөгөөд гүйцэтгэн захирах эрх мэдэл Ерөнхийлөгчийн удирдсан гүйцэтгэх салаа мөчирт хамаарна (*The Constitution of Korea, Article 66:4*). Ерөнхийлөгч түүний шууд удирдлагаар Засгийн газрыг удирдах Ерөнхий сайдыг томилно. Ерөнхийлөгч нь үндэсний Ассамблейн чуулганд оролцох, ханлаж үг хэлэх, түүний онцгой чуулганыг зарлан хуралдуулах, баталсан хуулинд хориг тавих зэрэг бүрэн эрхтэй юм. Тэрээр ерөнхий сайдаас гадна Ерөнхий шүүгч зэрэг өндөр албан тушаалтнуудыг Үндэсний Ассамблейтай зөвшилцөн томилдог. Дотоод үймээн самуун, гадаад халдан түрэмгийлэл, байгалийн гамшиг осол, санхүү эдийн засгийн хямрал зэрэг онцгой нөхцөл байдлын үед Ерөнхийлөгч нь зөвхөн үндэсний аюулгүй байдал, нийтийн энх тайван, дэг журмыг тогтоох шаардлагын үүднээс Үндэсний Ассамблейн хэлэлцэхийг хүлээлгүйгээр шаардлагатай эдийн засгийн арга хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр бүхий зарлиг гаргах улс орныг хяналтандаа авах эрхтэй болохыг Үндсэн хуульчилсан байдаг. Гүйцэтгэх салаа мөчрийн хүрээнд Ерөнхий сайд нь Ерөнхийлөгчийн удаад орох эрх мэдэл бүхий албан тушаал болно.

Тэхан Мингүг Күк Хе хэмээх Үндэсний Ассамблей буюу парламент нь нэг танхимтай, 299 гишүүнтэй бөгөөд бүрэн эрхийн хугацаа нь дөрвөн жил байна. Хууль тогтоох эрх мэдэл Үндэсний Ассамблейд хадгалагдана. Ассамблей нь шаардлагатай тохиолдолд тусгай асуудлаар мөрдөн байцаалт явуулах бүрэн эрхтэй байдаг. Түүнчлэн, Үндсэн хууль болон Үндэсний Ассамблейн тухай хуульд заасан төсвийн хяналтын эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Гэхдээ уг төсвийн эрх мэдэл нь Пакын судалснаар тус хууль тогтоох институтын идэвхгүй бүрэн эрх юм (Park, 2003: 495). Үндэсний Ассамблейн гишүүд болон Ерөнхийлөгчийг БНСУ-ын иргэд бүх нийтийн, тэгш, шууд ба, нууц санал хураалт бүхий сонгуулиар сонгоно (*The Constitution of Korea, Articles 41:1 and 67: 1*).

Солонгосын шүүх систем нь Дээд Шүүх, давж заалдах шатны шүүхүүд болон Үндсэн хуулийн Шүүхээс бүрддэг. Солонгосын эрх зүйн систем нь эх газрын Европын иргэний эрх зүйн систем, Англи-Америкийн эрх зүй, Хятадын сонгодог сургаал зэргийн элементүүдийг өөртөө агуулсан байдаг. Ялангуяа, Германы иргэний хуулийн систем нь Өмнөд Солонгосын эрх зүйн системийн үндэс болж ирсний учир нь "19 дүгээр зуунд Европын колоничлолын өргөжилт нь Ази, Африкийн олон оронд Ромын эрх зүйд үндэслэсэн иргэний эрх зүйн системийг авчирсан явдал юм" (Badr, 1977: 187).

Дээр дурьдсанаар, Үндсэн хууль нь гурван салаа мөчир бүхий удирдан захирах системийг тогтоосон. Тэдгээр нь Үндэсний Ассамблей дахь хууль тогтоох эрх мэдэл, ерөнхийлөгчийн удирдсан гүйцэтгэх салаанд хамаарах захиргааны чиг үүрэг, шүүхүүдэд хамаарах шүүх чиг үүрэг болно. Бүтцийн талаасаа эдгээр гурван салаа мөчир нь харилцан бие биенээсээ хараат бус байдаг. Үндэсний Ассамблейн гишүүдийг ард түмнээсээ сонгодог бол удирдлагыг нь гишүүд дундаасаа өөрсдөө сонгодог. Ерөнхийлөгчийн хувьд, тэрээр Ерөнхий сайд, Аудитын Газрын даргаас бусад гүйцэтгэх эрх мэдлийнхээ дээд албан тушаалтнуудыг томилохдоо Үндэсний

Ассамблейн зөвшөөрлийг авах шаардлагагүй байдаг. Дээд Шүүхийн тэргүүн болох Ерөнхий Шүүгчийг Ерөнхийлөгч Үндэсний Ассамблейтай зөвшилцөн томилдог боловч Ерөнхий Шүүгч нь Дээд Шүүхийн бусад шүүгчдийг Ерөнхийлөгчид санал болгох эрхтэй байдаг.

Өөр нэгэн тэмдэглэх чухал зүйл бол тус улсын эдийн засгийн хөгжилд үндсэн хууль дахь чөлөөт зах зээлийн эдийн засгийг дэмжсэн зарчмууд хүчтэй нөлөө үзүүлсэн юм. Үндсэн хуулиар хувийн болон хамтын эдийн засгийн эрх чөлөөг хангах явдлыг тунхагласан (*The Constitution of Korea*, Article 119:1-ийг үзнэ үү) билээ.<sup>82</sup>

### Abstract

This work covers historical and constitutional basis of a legislative institution of Korea. History of Korean parliamentary institution is a rich of development changes and challenges. Historical development and significance of the legislature has been studied by parliamentary scholars (Kim and Pai, 1981; Yoon, 1991; Park, 1998: 66-68, 2002a: 330-32) and practitioners or politicians such as former Members of the National Assembly (Kil, 1964: 1-12; Pak, 1976: 115-34) by various attempts. For instance, Park (1998) investigated the changes of the Korean legislature's policy activity in the context of the historical dimension. As Park briefly emphasized, the Korean National Assembly has a relatively short but turbulent history (Park, 1998: 68).

What history tells us is, according to the Potsdam declaration, Korea was set free from the 36 years of colonialism, and the nation was recovered its liberty on August 15, 1945. National liberation and its political assurances were not worry-free for Korean people at that time. As Pak Chan Hyun who was an assemblyman in the Constituent Assembly noted "... the nation was occupied by the United States forces in the south and the Soviet forces in the north respectively along the thirty-eighth parallel "for the sole and only purpose" of disarming the Japanese forces in Korea. The occupation of the two powers, however, has resulted in dividing the country into two halves. (Pak, 1976: 115).

*Key words: Korean National Assembly, legislature, constitution, Korean politics*

<sup>82</sup> Энэхүү өгүүлэл нь Солонгосын парламентын хөгжлийн талаарх цуврал өгүүллийн эхнийх болно.

## Ном зүй

Badr, Gamal Moursi. 1978. "Islamic Law: Its Relation to Other Legal Systems," *The American Journal of Comparative Law*. 26 (2), 187-198.

Blondel, Jean et al., 1970. "Legislative Behaviour: Some Steps Towards a Cross-National Measurement," *Government and Opposition*. 5 (1), 67-85.

Kil, Ki-sang, ed. 1964. *The National Assembly of the Republic of Korea*. Seoul: Kwang Myong Printing Co.

Kim, Chong Lim, and Byung-Kyu Woo. 1975. "Political Representation in the Korean National Assembly," In Boynton, G.R., and Chong Lim Kim, eds., *Legislative Systems in Developing Countries*. Durham: Duke University Press, 261-286.

\_\_\_\_\_, and Seong-Tong Pai. 1981. *Legislative Process in Korea*. Seoul: Seoul National University Press.

Mezey, Michael L. 1979. *Comparative Legislatures*. Durham, NC: Duke University Press.

National Assembly of the Republic of Korea. 1948. *The Constitution of Korea*.

Pak, Chan Hyun. 1976. *A Comparative Study of the Congress of the United States and the Korean National Assembly*. Seoul: Kwang Myong Printing.

Park, Chan Wook. 1998. "The National Assembly of the Republic of Korea," *The Journal of Legislative Studies*. 4 (4), 66-82.

\_\_\_\_\_. 2002. "Change Is Short but Continuity Is Long: Policy Influence of the National Assembly in Newly Democratized Korea," In Gerhard Loewenberg et al. eds., *Legislatures: Comparative Perspectives on Representative Assemblies*. Ann Arbor: University of Michigan Press, 329-351.

\_\_\_\_\_. 2003. "Budget Review in the National Assembly of Democratic Korea," *Journal of East Asian Studies*. 3 (3), 493-521.

Park, Il Kyung. 1962. "Review of the 14-Year History of Korean Constitutional Government," *Koreana Quarterly*. 4 (2), 23-34.

Yoon, Young O. 1991. *Korean Legislative Behavior: a Longitudinal Analysis in Comparative Perspective*. Seoul: Kookmin University Press.